



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/646

Булган сум

“Стандарттай Булган” арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Булган аймгийн 2025 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Х/74 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд амралт, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд “Стандарттай Булган” уриа дор зохион байгуулах стандартыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, зохион байгуулахад шаардлагатай 2,506,000 (хоёр сая таван зуун зургаан мянга) төгрөгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Шаардлагатай хөрөнгийг хөтөлбөр төлөвлөгөө, арга хэмжээний зардлын 24 дэх заалт “2025 оны аялал жуулчлалыг хөгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөө”-ний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 14-ний өдрийн
А. /646 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Хутаг-Өндөр суманд “Стандарттай Булган” уриан дор зохион байгуулах стандартыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний удирдамж

Нэг.Зорилго

Булган аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлж, аймгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжид стандартчилал, хэмжил зүйн салбарын бодлого шийдвэрийг сурталчлан таниулах, мэргэжлийн зөвлөгөө зөвлөмжөөр дэмжлэг үзүүлж, санал хүсэлтийг сонсож, шийдвэрлэх арга замыг тодорхойлох төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр.Хамрах хүрээ

Булган аймгийн амралт аялал жуулчлалын газрууд

Зохион байгуулагч байгууллага:

Булган аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс
Булган аймгийн “Аялал жуулчлалын холбоо” ТББ

Гурав. Хугацаа

2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Булган аймгийн Хутаг-Өндөр суманд зохион байгуулна.

Дөрөв. Зохион байгуулах арга хэмжээ:

Иргэн, аж ахуйн нэгжүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, холбогдох стандартын гарын авлагаар хангах;

(Тусгай хөтөлбөрөөр)

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Хэмжилзүйн тухай хуулийг сурталчлах, гарын авлага зөвлөмжөөр хангах

Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хийх;

Бүтээгдэхүүнд газар дээр нь үнэ төлбөргүй шинжилгээ хийх;

Тав. Хүлээгдэж байгаа үр дүн, тайлан

“Стандарттай Булган” арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж, үр дүнг тооцуулна.

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 14-ны/ний өдрийн
А/616 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Хутаг-Өндөр суманд “Стандарттай Булган” уриан дор зохион байгуулах
стандартыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг сайжруулах
арга хэмжээний удирдамж

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Шатахуун	литр	3,100	300	930,000
2	Хулдаасан хэвлэл /анонс/	м2	18,000	60	1,080,000
3	Бичгийн цаас	боодол	20,000	8	160,000
4	Принтерийн хор	ш	48,000	7	336,000
	Дүн				2,506,000